# ЗӨВЛӨМЖ

Иргэд хөдөлмөрчид та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Шинэ жилийн баярын арга хэмжээнүүд болж байгаа энэ үед цаг агаарын байдал хэвийн хэмжээнээс их хүйтэрч байгаатай холбогдуулан архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж бусдын амар тайван байдлыг алдагдуулахгүй, бага насны хүүхэд, өндөр настанг халамжлах хүнгүй эзэнгүй удаан хугацаагаар орхихгүй байхыг анхааруулж зөвлөмж хүргэж байна.

Төр төсвийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулахын зэрэгцээ "Архигүй шинэ жил"-ийн арга хэмжээ зохион байгуулахыг уриалж байна.

Баталгаагүй газраас цацардаг тэсэрдэг солют хэрэглэхгүй байх, хугацаа нь дууссан түргэн мууддаг, хадгалалтын горим алдсан хүнсний бүтээгдэхүүн худалдан авахгүй байх, үйлдвэрлэсэн он, хадгалсан байдлыг хангасан бэлэг хүүхдүүддээ өгөхөд анхаарах хэрэгтэй.

Гэр бүлийн хүрээнд болон нийтийн арга хэмжээний үеэр үдэж байгаа 2016 ондоо хийсэн бүтээсэн, ололт амжилтаараа бахархаж, соёлтой бүтээлч байдлаар тэмдэглэн, 2017 ондоо сэтгэл хангалуун урам зоригтой эрч хүчээр дүүрэн ажиллахын ерөөл өргөн дэвшүүлэн мэндчилье.

Сайхан сумын

Засаг дарга D.Доржданва